



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 04 сарын 05 өдөр

Дугаар А/193

Булган


Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29.1.3, 29.1.3 /а/, Малын генетик нөөцийн тухай хуулийн 14.1, 14.1.1, УИХ-ын 2015 оны 104 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого”-ын 2.1.4, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалын “Засаг даргын нөөц хөрөнгийг зарцуулах журам”-ын 2.1.1, 2.1.4, Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны “Хөгжлийн хөтөч” хөтөлбөрийн 2.2.1, аймгийн Онцгой комиссын 2019 оны 01 сарын 11-ний өдрийн 02 тоот хурлын шийдвэрийн 4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Шинэ хөдөө” төслийн хүрээнд малын чанар, үүлдэр угсааг сайжруулах зорилгоор худалдан авч Хутаг-Өндөр суманд өвөлжүүлсэн Дархад үүлдрийн хурган хуц, Эрчимийн хар омгийн ухна ишгийг нэмэгдэл тэжээлээр тэжээхэд зориулж аймгийн Нөөцийн газрын бэлтгэсэн 2400 боодол өвс, 400 шуудай хивэг, тэжээлийг үнэгүй олгохыг зөвшөөрсүгэй.

2. Дээрх хэмжээний өвс, тэжээлийг аймгийн Нөөцийн газраас зарцуулахыг аймгийн Нөөцийн газар /Д.Баярмагнай/-т, хүлээн авч, тээвэрлэх ажлыг зохион байгуулахыг Хутаг-Өндөр сумын Засаг дарга П.Итгэлбаяр нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



З.БАТЗОРИГ